6.1. Анги бүлэг үүсгэх

Энэхүү үйлдлийг сургуульд анги бүлэг шинээр үүсгэхэд ашиглана.

Сургуульд анги, бүлэг шинээр бүртгэх үйлдлийг хийхэд дараах алхамчилсан дараалын дагуу бүртгэнэ.

1. Боловсролын удирдлага- Анги бүлэг модулийг сонгоно.



2. Бүлэг үүсгэх үйлдлийг хийнэ.

-Шинээр үүсгэх анги бүлгийн мэдээллийг дараах талбаруудад оруулж хадгална.





6.2. Анги бүлгийн бүртгэл засах

Энэ үйлдлийг сургуульд үүсгэсэн байгаа ангийн мэдээллийг засахад ашиглана. Анги бүлгийн мэдээллийг засах үйлдлийг хийхэд дараах дараалын дагуу хийнэ.

- Анги бүлэг үйл ажиллагааг сонгоно.



- Засах гэж буй ангийг сонгож **Үйлдэл** гэсэн товч дарна.



- Гарч ирсэн цонхонд **Бүлэг засах** үйлдэл дарснаар тухайн бүлгийн мэдээллийг засах талбар гарч ирнэ..



Анги бүлгийн мэдээлэл устгах алхамчилсан дараалал дараах байдалтай байна.

Таб дах мэдээлэл	Тайлбар
Үндсэн мэдээлэл	Бүлгийн үндсэн мэдээллийг харуулна. Бүлгийн мэдээллийг өөрчилж хадгалсан бол засагдаж өөрчлөгдсөн хамгийн сүүлийн бүлгийн үндсэн мэдээллийг харуулна.
Суралцагч	Бүлэгт бүртгэлтэй суралцагчийн жагсаалтыг товч мэдээллээр хүснэгт хэлбэрээр харуулахаас гадна бүлэгт бүртгэлтэй суралцагчийг төлвөөр нь индикатораар харуулна.
Багш	Анги бүлэг удирдсан болон туслах багшийн мэдээллийг харуулна. Хэрэв анги удирдсан болон тухайн бүлгийн туслах багшийн мэдээллийг оруулаагүй бол бүлэг засах үйлдэл хийж анги

	удирдсан багшийг сонгож оруулна.

6.3. Анги бүлгийн бүртгэл устгах

Үүсгэсэн анги бүлгийн мэдээллийг устгахад ашиглана.

Анги бүлгийн мэдээллийг дараах алхамчилсан дараалын дагуу устгах үйлдлийг хийнэ.

1. Боловсролын удирдлагын-Анги бүлэгийн модулийг сонгоно



Анги бүлгийг сонгоход дараах цонх нээгдэх бөгөөд үүсгэсэн ангибүлгүүд жагсаалтаар харагдах бөгөөд устгах ангийг сонгоно.



Уг үйлдлийг хийснээр 3 янзын сонголт (Бүлэг засах, Бүлэг устгах, Бүлгийн мэдээлэл) гарч ирэх бөгөөд **Бүлэг устгах** гэсэн сонголтыг сонгоно.



Бүлэг устгах гэсэн сонголт хийхэд дараах цонх харагдана.**Бүлэг устгах** товчийг дарж өгсөнөөр устгах үйлдэл амжилттай болно.



6.4 Анги бүлэгт Анги удирдсан багш оноож өгөх

1. Боловсролын удирдлага -ын **Анги, бүлэг** модулийг сонгоно.



2. Анги, бүлгийн нэр дээр дарж **хариуцсан багшийн нэмэх** товчийг дарна.



3. Хариуцсан багшийн нэрийг сонгож хариуцсан үүрэг хэсэгт Анги удирдсан багш гэж сонгож хадгалах үйлдэл хийнэ.


Шинэ бүлэг
Хадгалах
* Хичээлийн жил
2021-22 Хичээлийн жил (
* Бүлгийн нэр
1а
* Бүлгийн төрөл
Хөтөлбөрийн бүлэг
* Хөтөлбөр
Бага боловсролын өдрийн
Бүлгийн хэлбэр
Үндсэн бүлэг
* Анги
1-р анги
* Хичээллэх эзлэх
1-р эзлэх
* Ангилал
Үндсэн бүлэг
Салбар, бүрэлдэхүүн
Сэлэнгэ аймгийн Мандал
* Сургалтын байгууллага
Сэлэнгэ аймгийн Мандал
Тайлбар
Хариуцсан багш
№
Хариуцсан үүрэг
1
Б.Гэрэлмаа
Анги удирдсан багш
Бүлгийн өрөө
+Өрөө нэмэх
№
Анги, Танхим
Төрөл
Тоот
Байр
Харуулах мэдээлэл байхгүй байна.